



МОНГОЛ УЛС  
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ  
ТОГТООЛ

2015 оны 03 сарын 11 өдөр

Дугаар 127

Улаанбаатар хот

“Хөнгөн бетон” ХК-ийн хяналтын багц эзэмшигчдээс  
Компанийн тухай хуулийн 57.1 дэх заалтыг хэрэгжүүлэх, хувьцааг  
худалдан авахаар гаргасан саналыг зөвшөөрөх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, Компанийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1, Санхүүгийн зохицуулах хорооны 2010 оны 163 дугаар тогтоолоор батлагдсан “Хувьцаат компанийн хувьцааг заавал болон сайн дурын үндсэн дээр худалдан авах санал гаргах ажиллагааны журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Хөнгөн бетон” ХК-ийн нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий нийт гаргасан 179 373 ширхэг хувьцааны 43.01 хувь буюу 77 148 ширхэг хувьцаа эзэмшигчид болох Н.Эрдэмбаяр, Н.Эрдэмбилэг нараас тус хувьцаат компанийн бусад хувьцаа эзэмшигчдийн өмчлөлд байгаа нийт хувьцааны 56.99 хувь буюу 102 225 ширхэг хувьцааг нэг бүрийг нь 200 /хоёр зуу/ төгрөгөөс доошгүй үнээр худалдан авах санал гаргасныг зөвшөөрч хүчинтэй байх хугацааг 2015 оны 02 дугаар сарын ...-ны өдрөөс эхлэн ажлын 60 хоногоор тогтоосугай.

2. “Хөнгөн бетон” ХК-ийн хувьцааг нэгдмэл сонирхолтой эзэмшигчид болох Н.Эрдэмбаяр, Н.Эрдэмбилэг нараас бусад хувьцаа эзэмшигчдийн хувьцааг худалдан авах санал гаргаж байгаатай холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг хувьцаа эзэмшигч Н.Эрдэмбаяр, Н.Эрдэмбилэг нарт үүрэг болгосугай.

1/ Компанийн тухай хуулийн 57.3-т заасны дагуу хувьцааг худалдан авах саналаа нийтэд сурталчилж, хуулиар хүлээсэн үүргээ хугацаанд нь биелүүлэх, хувьцааг худалдан авах саналын хугацаа дуусмагц ажлын 5 хоногт багтаан хувьцааг худалдан авах саналын хэрэгжилтийн тайланг тус Хороонд ирүүлэх;

030078

2/ Санхүүгийн зохицуулах хорооны 2013 оны 505 дугаар тогтоолоор батлагдсан “Үнэт цаас гаргагчаас мэдээллийг нийтэд тогтмол хүргэх тухай журам”-д заасан мэдээллийг цаг тухайд нь тогтмол ирүүлж, хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ чанд биелүүлж ажиллах;

3/ Санхүүгийн зохицуулах хорооны 2014 оны 162 дугаар тогтоолоор шинэчлэн батлагдсан “Компанийн засаглалын кодекс”-ийг цаашид компанийн үйл ажиллагаанд мөрдөж ажиллах.

3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Ц.Энхбаяр/-нд даалгасугай.

ДАРГА



З.НАРАНТУЯА